

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД
ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх түвшин	Хариуцах этгээд	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Үнэлгээ
Нэг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр						
1.1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн санал боловсруулах (ГБХТХ-ийн 12.1.3)	Саналыг боловсруулж, ХЗДХ-н сайдад танилцуулсан эсэх	ХЗДХЯ ГХУСАЗЗАА	Дэд зөвлөлийн гишүүд НҮБХАС	НҮБХАС-ийн дэмжлэгтэйгээр хийхээр төлөвлөсөн хуулийн шийдвэрлэлтэй найруулгын төсөл боловсруулах ажил тодорхойгүй хугацаагаар хойшилсон.	0
1.2	Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартыг шинэчлэн боловсруулах (ГБХТХ-ийн 35.10)	Стандартын төслийг шинэчлэн боловсруулсан эсэх	ГБХНХЯ	ХГБХХЕГ	ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ний А/289 дүгээр тушаалаар Түр хамгаалах байрыг төрөлжүүлэн зохион байгуулах хэрэгцээ, шаардлагыг судлах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Ажлын хэсгээс түр хамгаалан байрлуулах үйлчилгээг төрөлжүүлэн зохион байгуулахтай уялдуулан Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байгаа тул хойшлуулах саналыг Стандарт, хэмжил зүйн газарт 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 05/3383 тоот албан бичгээр хүргүүлсэн.	50
1.3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх дунд хугацааны төлөвлөгөөг батлуулах (ГБХТХ-ийн 9.1.1, 10.1.1)	Төлөвлөгөө батлагдсан эсэх	ГХУСАЗЗАА	Дэд зөвлөлийн гишүүд	ГХУСАЗЗАА-аас НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дунд хугацааны төлөвлөгөөний төслийг эцэслэн боловсруулсан. Төлөвлөгөөний төслийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлээ.	70

1.4	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах нь: Олон талт зөвлөлдөх уулзалт зохион байгуулах (ГБХТХ-ийн 12.1.2)	Зохион байгуулсан уулзалт Оролцогчийн тоо (хүйсээр)	ХЭҮТ	Дэд зөвлөлийн гишүүд	Улсын дээд шүүхээс 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр ХЭҮК-ын гишүүн Ж.Хунан болон холбогдох мэргэжилтнүүдийг хүлээн авч, уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар хүүхдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эмзэг хохирогчоос мэдүүлэг авах ажиллагааны онцлог, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг, чадавхийн асуудлаар санал солилцлоо. Мөн УДШ, Шүүхийн аадеми, ОУЭХБ-аас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Дагнасан шүүхийн тогтолцоо: Гэр бүл, хүүхдийн эрх ашиг ба гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх” сэдэвт олон улсын хурлыг зохион байгууллаа. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс цахим орчин дахь жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллага, Азийн сантай “Технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр хамтран ажиллаж байна. Мөн Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны ээлжит хуралдаанд Иргэний нийгмийн Хүний эрхийн форумын төлөөлөл оролцож, “Гэр бүлийн хүчирхийлэл: Асуудал ба шийдэл” сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа. Уг уулзалт гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн хэрэгжилт, хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, тулгамдаж буй	100
-----	--	--	------	----------------------	---	-----

					асуудлууд болон цаашид авах бодитой арга хэмжээний талаар Иргэний нийгмийн байгууллагууд байр сууриа илэрхийлж, санал, дүгнэлтээ танилцуулсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлийн хүчирхийлэлд өртөх эрсдэлийг бууруулах, тэдэнд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулах асуудлаар "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах нь" Зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа.	
1.5	Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэгдсэн этгээдийн хувийн мэдээллийг иргэд, олон нийтэд ил болгохтой холбоотой хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ХЗДХЯ-нд хүргүүлэх	Хүргүүлсэн үндэслэл бүхий санал	ЦЕГ	-	Цагдаагийн байгууллагаас хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэж ял шийтгэгдсэн этгээдийн мэдээллийг иргэд олон нийтэд ил тод болгох талаар судалж холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаар насанд хүрээгүй хүний эсрэг хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн сүүлийн 5 жилийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, судалгааны хариунд үндэслэн тодорхой санал боловсруулан ГХУСА33-д хүргүүлсэн. Уг саналын хүрээнд ГХУСА33АА-аас Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн этгээдийн хувийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулж, уг ажлыг мөн яамны Хууль зүйн бодлогын газарт хариуцуулах талаар ХЗДХ-ийн сайдад танилцуулга хүргүүлэн шийдвэрлүүлж, хүргүүлсэн.	100

					Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг давтан үйлдсэн талаарх судалгааг Гэмт хэргийн цагаан ном-2024 эмхтгэлийн хавсарга судалгаа болгон бэлтгүүлж, Хууль зүйн бодлогын газарт хүргүүлээ.	
1.6	Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх	Үнэлгээний тайлан гарсан эсэх	ШШГЕГ	ХЭҮТ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас Дотоод хэргийн их сургуулийн эрдэм шинжилгээний хүрээлэн хамтран баривчлах шийтгэл эдэлж буй этгээдүүдийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, гадаадын зарим орны сайн туршлагыг судлах зорилгоор “Баривчлагдсан этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалтын хэрэгжилт, тулгамдсан асуудал” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Энэ хүрээнд ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгээс сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх ажлыг зохион байгууллаа. Судалгааны үр дүнгээр сургагч багшийг бэлдэж мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, сургалтын үйл ажиллагааг явуулах төсөвтэй болох, эрх зүйн зохицуулалтын хүрээнд болон үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тохирсон сургалтын хөтөлбөртэй болох, цөөн хүнтэй бүлгээр хичээллэх, сургалтын цаг, тоо давтамжийг нэмэгдүүлэх, сургалтын анги танхим, хичээлийн материал хэрэглэгдэхүүний хүрэлцээг сайжруулах, суралцагчдын идэвх оролцоог нэмэгдүүлж багаар ажиллуулах боломж шийдлийг эрэлхийлэх хэрэгцээ шаардлагатай гэж дүгнэжээ.	100
Хоёр. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд						

2.1.	Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмын хэрэгжилтийн судалгаа хийх (ЭХХШтХ-ийн 29.6)	Судалгааны тайлан гарсан эсэх	УЕПГ	МХЭССХ	Прокурорын байгууллагаас өсвөр насны сэжигтэн, яллагдагчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх журмын хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх, өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Улсын ерөнхий прокурорын орлогчийн 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр баталсан удирдамжийн дагуу, өсвөр насны сэжигтэн, яллагдагчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх журмын хэрэгжилтийг 2025 оны III улирлын байдлаар судалсан. Тус судалгааны хүрээнд: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д заасан “гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй” үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэрэг, өсвөр насны сэжигтнийг баривчлах, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын санал, мөрдөгчийн тогтоол, шүүгчийн захирамж, дуудан ирүүлэх тухай прокурорын мэдэгдэх хуудас болон бусад холбогдох баримтуудыг хамруулсан байна. Судалгааны дүн, цаашид анхаарах асуудлын талаар нэгж прокурорын газруудад мэдээлэл хүргүүлсэн бөгөөд хүүхэд хохирсон болон холбогдсон хэрэгт дагнан хяналт тавьж ажилладаг прокуроруудыг чадавхжуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөөд байна. Дээрх судалгааны хүрээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газартай хамтран	90
------	--	-------------------------------	------	--------	---	----

					хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд хамгааллын мэргэжилтэн, сум хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг нийт 815 албан хаагчдад “Хууль ёсны төлөөлөгчийн эрх, үүрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарвал зохих асуудал” сэдэвт сургалт зохион байгуулж ажиллаа.	
2.2	Зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээсэн өсвөр насны хүний нийгэмшихүйг дэмжих ажил, үйлчилгээний байдалд хүүхдийн оролцоотой хөндлөнгийн үнэлгээ хийж, үр дүнг хэлэлцүүлэх (ГБХТХ-ийн 22.1.2)	Үнэлгээний тайлан гарсан эсэх	МХЭССХ	ХГБХХЕГ ШШГЕГ	Монголын Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэнгээс хууль зөрчсөн өсвөр насны хүүхдийн нийгэмшлийг дэмжих байдалд ихэвчлэн баривчлах шийтгэл хүлээсэн өсвөр насны нийслэлийн 34 хүүхдийг оролцуулан богино хэмжээний, туршилтын үнэлгээг хийж, тайланг гаргасан. Энэхүү үнэлгээ нь өсвөр насны хүүхдийн нийгэмшлийн түвшин, тэднийг хүрээлэх орчны дэмжлэг, хүүхдийн дотоод нөөц, зан үйл, хөгжлийн хэрэгцээг цогцоор нь тодорхойлох зорилготой. Үнэлгээний агуулга дараах хэсгүүдээс бүрдэнэ: •Нийгэмшил ба хэмжүүр – өсвөр насны хүүхдийн нийгэмшлийг тодорхойлох гол үзүүлэлт, харилцааны чадвар, зан үйлийн хэм хэмжээ, нийгмийн оролцоог үнэлнэ. •Нийгэмшлийн ерөнхий байдал – давуу тал, тулгамдсан асуудал, хүүхдийн нийгмийн оролцооны түвшинг тоймлон харуулна. •Гадаад орчны дэмжлэг – гэр бүл, сургууль, хамт олон, цахим орчны нөлөөлөл, хамгаалах-эрсдлийн хүчин зүйлсийг үнэлнэ. •Дотоод орчны чанар – хүүхдийн сэтгэлзүй, өөрийгөө үнэлэх, зорилго чиглэл, стресс даван туулах чадварыг тодорхойлно.	90

				•5 орчны нийлмэл үнэлгээ – гэр бүл, сургууль, хамт олон, нийгмийн үйлчилгээ, хүүхдийн хувийн орчны нэгдсэн дүнг гаргана. •Гол хэрэгцээ ба зөвлөмж – нийгэмшлийг дэмжихэд шаардлагатай орчны өөрчлөлт, эцэг эх ба мэргэжлийн байгууллагад өгөх чиглэл, бодит зөвлөмжийг багтаана. Энэхүү үнэлгээ нь хүүхдийн хөгжлийн бодит хэрэгцээг илрүүлж, нийгэмшлийг сайжруулах цогц арга хэмжээ төлөвлөхөд чухал суурь мэдээлэл болдог. Уг тайланд үндэслэн хууль зөрчсөн, өсвөр насны хүүхдийн асран хамгаалагчид зориулсан гарын авлага, зөвлөмжийг боловсруулсан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газраас Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх төслийн хүрээнд хүрээнд хууль зөрчсөн өсвөр насны хүүхдэд хэрэгжиж буй “Нийгэмшихүйн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажилладаг албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг аймаг, дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нийт 85 албан хаагчид зохион байгууллаа. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээнд 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар гэмт хэрэгт сэжигтэн 204, зөрчил үйлдэж шийтгэгдсэн 304, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 297, нийт 805 хүүхэд бүртгэлтэй байгаагаас 658 хүүхэд нийгэмшихүйн хөтөлбөрт хамрагдсан. Нийгэмшихүйн хөтөлбөрт хүүхдийн оролцоотой хөндлөнгийн үнэлгээ хийгдээгүй байгаа болно.	
--	--	--	--	---	--

2.3	“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр сэтгүүлчдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах	Боловсруулсан сургалтын хөтөлбөр Сургалтын тоо Оролцогчийн тоо	ГХУСА33АА	ЖҮХАА	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга, НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгч нарын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хамтран ажиллах төлөвлөгөө, 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн шинэчлэн баталсан төлөвлөгөөний дагуу Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Аяны хүрээнд Эдвина ХХК-тай хамтран сэтгүүлчдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Мөн НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр “Жендэрийн мэдрэмжтэй мэдээлэх нь” сэдэвт сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан сургалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа “Төр хур” амралт, сэргээн засах сувилал УТҮГ-т зохион байгууллаа. Сургалтад хамруулахаар нийт 40 хэвлэл мэдээллийн байгууллагад албан бичгээр хандсанаас Зууны мэдээ сонин, Өдрийн сонин, Ийгл ТВ, Малчин ТВ, mass.mn, ubn.mn, tsahiur.mn, itoim.mn, urug.mn, zug.mn, bichleg.mn, child.mn, bolod.mn, zuv.mn, isee.mn зэрэг 20 хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч оролцов. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төв, Архивын ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг,	100
-----	--	---	-----------	-------	--	-----

					Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг 11 байгууллагын хэвлэл мэдээлэл хариуцсан нийт 31 (эр-5, эм-26) албан хаагч оролцлоо.	
2.4	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, танилцуулах (ГБХТХ-ийн 44.2)	Шинэчилсэн сургалтын хөтөлбөр	ХЭҮТ	-	Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс Австралийн Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр, гэр бүл болон эрчүүдтэй холбоотой асуудлаар ажилладаг төрийн бус байгууллагын төлөөлөл, мэргэжилтнүүдийг чадавхжуулах, зан үйлд нөлөөлөх сайн дурын боловсруулсан хөтөлбөрийн дагуу сургалтын сургагч багш болгон бэлтгэх зорилго бүхий сургалт 2025 оны 5 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн сургалтын танхимд амжилттай зохион байгуулагдлаа. Уг сургалтад нийт 21 оролцогч хамрагдлаа.	100
2.5	Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хамтарсан багийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах (ГБХТХ-ийн 12.1.5)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр) Сургалтын үр дүн (чанараар)	ГБХНХЯ	ХГБХХЕГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны А/102 дугаар тушаалаар Салбарын хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангах чиглэлээр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтэс, дүүрэг, харьяа байгууллагын албан хаагч нарт хууль эрх зүй, хүүхдийн хөгжил, хамгаалал, сэтгэл зүйн зөвлөгөө, хувь хүний хөгжлийн чиглэлээр олон талт мэдээлэл өгөх мэргэшүүлэх цахим сургалтыг 16 удаа зохион байгуулж нийт 4371 албан хаагчдыг хамруулсан. Мөн Сайн иргэн-Сайн ирээдүй НҮТББ-аас санаачлан хэрэгжүүлсэн “Хүүхдийн сэтгэл хөдлөл, практик аргачлал”- сэдэвт сургалтад түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн 80 албан хаагчийг хамруулсан.	100

					Цагдаагийн ерөнхий газрын харьяа Мэдээлэл, шуурхай удирдлагын төвтэй хамтран гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр олон талт мэдээлэл олгох сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж 602 хамтарсан багийн 6968 гишүүд, Хүүхдийн тусламжийн утас 108 дуудлагын төвийн албан хаагч, аймаг, дүүргийн түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн 280 ажилтан, албан хаагчдыг давхардсан тоогоор хамруулсан. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс Чингэлтэй дүүргийн зарим хороодын нийгмийн ажилтнуудын бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбогдуулан, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн гишүүдийн чадавхыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг илрүүлэх, хамгаалах, хуулийн хүрээнд таслан зогсоох, хохирогч төвтэй үйлчилгээ үзүүлэх ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Чингэлтэй дүүргийн 22 хорооны нийгмийн ажилтан оролцсон бөгөөд тэд хамтарсан багийн үйл ажиллагаанд үр дүнтэй хамтран ажиллах, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг илрүүлэх, хамгаалах, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр мэдлэг, ур чадвараа дээшлүүллээ.	
2.6	“Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх” сургалтыг зохион байгуулах (ГБХТХ-ийн 12.1.5)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр) Сургалтын үр дүн (чанараар)	ХЗТТ	-	Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн уг сургалтыг зохион байгуулах боломжгүй болсон.	0

2.7	Хууль сахиулах, нийгмийн хамгааллын салбарын сургагч багшаар бэлтгэгдсэн алба хаагчдаар дамжуулан салбарын албан хаагчдын хөгжлийн бэрхшээлтэй хүний болон бэлгийн цөөнхийн эрхийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах (ГБХТХ-ийн 12.1.5)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр) Сургалтын үр дүн (чанараар)	ЦЕГ, ШШГЕГ, ШШЕГ, ДХИС, ХЗТТ, ХГБХХЕГ	ГХУСАЗЗАА	ХЗДХ-ийн салбарын хэмжээнд 2025 оны байдлаар нийт 61 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, танхимаар болон цахимаар нийт 3630 үүнээс 2710 ажилтан албан хаагч, 920 их сургуулийн сонсогч хамрагджээ. Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2025 оны А/70 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэх 2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-нд заагдсан “Зорилтот бүлгийн иргэнтэй харилцах алба хаагчдын сургалт”-ыг энэ оны 11 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 41 алба хаагчийг хамруулж, гэрчилгээг гардуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход учирч буй саад бэрхшээлийг арилгах, хөгжлийн бэрхшээлийн талаар эерэг ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх, алба хаагчдын ойлголт, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй харилцах онцлог, ур чадвар, арга барилыг эзэмшүүлэх, дохионы хэлний анхан шатны мэдлэгийг эзэмших, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагын алба, нэгжийн 24 цагаар үүрэг гүйцэтгэдэг жижүүрийн цагдаа, эргүүлийн цагдаа, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч холбогдогч нарыг хүлээн авдаг хамгаалах байрны нийгмийн ажилтан зэрэг хэрэгцээ шаардлага бүхий 41 алба хаагчдыг сургалтад хамруулсан. Нутаг дэвсгэр хариуцсан 38 цагдаагийн байгууллагын Угтах	100
-----	---	---	---------------------------------------	-----------	---	-----

					үйлчилгээний зааланд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг дараалалгүй үйлчлүүлэх тусгай тэмдэглэл стандартын дагуу хийж, харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй орчныг бүрдүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагын 38 нэгжийн 117 өрөө, тасалгааны хаяг, тэмдэг, тэмдэглэгээг брайл үсгээр хийж байршуулсан. Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний бэрхшээлийн онцлогийг алба хаагчдад таниулах зорилгоор Архангай, Ховд, Увс, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь аймгийн Цагдаагийн газрууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй зөв харилцах мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлийн төрөл ангилал, тэдгээрийн онцлог, зөв харилцах зарчим, хүний эрхийн хандлага, цагдаагийн үүрэг оролцооны талаар мэдлэг олгосон. -Танхимын сургалтыг 1-2 удаа мэргэшсэн багш, туршлагатай иргэдийн оролцоотой хэлэлцүүлэг, кейс судалгаа, видео ашиглан мэдээллийг өгч ажилласан. Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон "Жишиг асуулгын гарын авлага"-ыг боловсруулан Хүний эрхийн үндэсний комиссоор хянуулж, хүүхдийн эрхийг хангах, зөрчигдсөн эрхийг хамгаалах, хүний эрхийн мэдрэмжтэй ажиллах, мөрдөгч нараас гаргах алдаа, дутагдлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн практик ач холбогдолтой ажил болсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах хүртээмжийн судалгаа, үнэлгээ хийх, албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, арга зүйн зөвлөгөөний	
--	--	--	--	--	--	--

				удирдамж"-ийн хүрээнд дараах ажлуудыг шат дараатай хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1."Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хууль эрх зүйн орчин, хүний эрхэд суурилсан хандлага, дохионы хэлний анхан шатны мэдлэг олгох" агуулгын хүрээнд нийт 6 удаагийн сургалтыг зохион байгуулж 261 алба хаагчдыг (үүнээс 120 эрэгтэй, 141 эмэгтэй) хамруулаад байна. 2.2025.11.03-07-ны өдрүүдэд 9 дүүргийн цагдаагийн хэлтсийн 41 алба хаагчийг хамруулан сургалт зохион байгуулсан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад тулгамдаж буй саад бэрхшээлийг тодорхойлох тандалт судалгаа", "Барилга байгууламжийн саадгүй байдлыг үнэлэх" судалгааг гүйцэтгэж байна. Энэ чиглэлээр судалгааны багийн гишүүд 2025 оны 5 дугаар сарын 08-ны өдөр 421, 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид үнэлгээ хийж ажилласан. Мөн 407, 421 дүгээр нээлттэй хорих ангийн 49 алба хаагчдад "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай ойлголт" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зорилгоор "Дохионы хэлний анхан шатны чадвар" эзэмшүүлэх сургалтад хорих анги, байгууллага, салбар нэгжийн 38 алба хаагч нарт зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.	
--	--	--	--	--	--

					Шүүх шинжилгээний ерөнхий газраас “Хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”-ны Удирдах зөвлөлийн дарга, дохионы хэлний хэлмэрч, орчуулагч багш Б.Саранчимэгтэй анхан шатны дохионы хэлний сургалт зохион байгуулах тухай хамтран ажиллах гэрээ байгуулж, энэ оны 04 дүгээр сарын 17-ний өдрөөс 05 дугаар сарын 19-ний өдрийн хооронд сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор 15 алба хаагч сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцах арга барил, дохионы хэлний анхан шатны сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан. Мөн “Хөгжлийн бэрхшээл ба тэгш эрх сэдэвт сургалтад ШШЕГ-ын 218 алба хаагч, Өмнөговь аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төвийн 10 эрэгтэй, 6 эмэгтэй нийт 16 алба хаагч аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас зохион байгуулсан "Тэгш хүртээмж-Тэгш боломж" хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг, арга хэмжээнд оролцож, сургалтад хамрагдсан. Архангай аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 5 эрэгтэй, 5 эмэгтэй нийт 10 алба хаагч аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр тус төвийн мэргэжилтнийг урьж, "Хүртээмж" сэдэвт сургалт зохион байгуулсан байна. Говьсүмбэр аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 1 алба хаагч аймгийн Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвөөс 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулсан	
--	--	--	--	--	--	--

					дохионы хэлний анхан шатны сургалтад хамрагдсан. Дундговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсээс аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн мэргэжилтэн Н.Бямбааг 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр урьж, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй хэрхэн ажиллах, барилга байгууламжийн дотор болон гаднах стандартыг хэрхэн мөрдөж ажиллах" сэдэвт сургалтад хэлтсийн 6 эрэгтэй, 4 эмэгтэй нийт 10 алба хаагч хамрагдсан. Дорноговь аймгийн Шүүх шинжилгээний хэлтсээс тус аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Б.Энхзулыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр урьж, "Хөгжлийн бэрхшээл ба тэгш ойлголт" сургалтад хэлтсийн 6 эрэгтэй, 5 эмэгтэй нийт 11 алба хаагч танхимаар хэсгийн 4 алба хаагч цахимаар хамрагдсан.	
2.8	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах (ГБХТХ-ийн 12.1.5)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр)	ХГБХХЕГ	ГХУСАЗЗАА ГБХНХЯ МХЭССХ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газраас 2025 онд шинчлэн байгуулагдсан 38 хууль зүйн хороо (494 гишүүнтэй)-ны гишүүдийг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, арга зүй өгөх сургалтыг 2 удаа цахимаар зохион байгуулж 417 гишүүн, харьяа газар хэлтсүүд 21 удаагийн сургалтад 309 гишүүн, нийт давхардсан тоогоор 726 гишүүнийг хамруулсан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд 2 удаа зөвлөмж хүргүүлж, төлөвлөгөөт болон шуурхай 88 удаагийн хурлыг зохион байгуулж, 123 шийдвэр гарган хэрэгжилтийг ханган ажиллаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч 57 хүүхдэд үзүүлж буй үйлчилгээнд арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх төслийн хүрээнд хүрээнд хууль зөрчсөн өсвөр	100

					насны хүүхдэд хэрэгжиж буй “Нийгэмшихүйн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажилладаг албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг аймаг, дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажлын алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгч нийт 85 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Давхардсан тоогоор 811 Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүнийг чадавхжуулах сургалтад хамруулсан. Монголын хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэнгээс хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах энэ хүрээнд орон нутгийн ХГБХХБ-тай холбогдон санал гаргаж, сум дундын шүүхтэй орчинд ажиллах хүүхдийн эрхийн найман хууль зүйн хороонд ажиллаж сургалт, арга зүйн тусламж үзүүлэхийг зорьж тэдгээрээс 5 хороонд хүрч хорооны удирдлага, гишүүдтэй нь хамтран ажилласан. Мөн аймаг, дүүргийн ХГБХХБ-ын санал, хэрэгцээг үндэслэн хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чадавхжуулах сургалт, зөвлөгөөнд ороцох, захиалгат сургалтыг гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэв					
					<table><tr><td>Гол онцлог, тайлбар</td><td>Хамарсан хүрээ, хүн, сургалтын цаг</td></tr><tr><td>Сэлэнгэ аймагт нийт хүүхдийн эрхийн хууль зүйн гурван хороо ажилладаг. Хоёр нь сум дундын шүүхтэй нэр бүхий сумдад ажиллаж нийт 9 сум хамаардаг.</td><td>Хоёр сумын ХЭХЗХ-ны 25 гишүүдэд сум бүрд 8, нийт 16 цагийн хичээл, сургалт, арга зүйн зөвлөгөө өгөв.</td></tr></table>	Гол онцлог, тайлбар	Хамарсан хүрээ, хүн, сургалтын цаг	Сэлэнгэ аймагт нийт хүүхдийн эрхийн хууль зүйн гурван хороо ажилладаг. Хоёр нь сум дундын шүүхтэй нэр бүхий сумдад ажиллаж нийт 9 сум хамаардаг.	Хоёр сумын ХЭХЗХ-ны 25 гишүүдэд сум бүрд 8, нийт 16 цагийн хичээл, сургалт, арга зүйн зөвлөгөө өгөв.	
Гол онцлог, тайлбар	Хамарсан хүрээ, хүн, сургалтын цаг									
Сэлэнгэ аймагт нийт хүүхдийн эрхийн хууль зүйн гурван хороо ажилладаг. Хоёр нь сум дундын шүүхтэй нэр бүхий сумдад ажиллаж нийт 9 сум хамаардаг.	Хоёр сумын ХЭХЗХ-ны 25 гишүүдэд сум бүрд 8, нийт 16 цагийн хичээл, сургалт, арга зүйн зөвлөгөө өгөв.									

					Завхан аймгийн Тосонцэнгэл сумын ХЭХЗХ-ны гишүүдийн 8 цагийн сургалт, семинар	Хамгийн олон буюу 9 сумын НА-ууд болон аймгийн ХЭХЗХ ны АА ны нийт 15 хүнд 8 цагийн сургалтыг Ментор багш явуулав.
					Өмнөговь аймгийн болон Ханбогд сумын ХЭХЗХ ны гишүүд болон шинэ нийгмийн ажилтнууд нийт 40 хүн 8 цагийн сургалт, семинар	Хууль зүйн хоёр хорооны гишүүдээс гадна хүүхэд, гэр бүлийн шинэ нийгмийн ажилтнууд нийт 40 гаруй хүнд 8 цагийн сургалт явагдав.
					СХД-ийн Боловсролын, эрүүл мэндийн, хөдөлмөр, нийгмийн халамжийн, цагдаагийн, Прокурор, шүүх, ШШГБ-ын, ХГБХХБ-ын нийгмийн ажилтны, нутгийн захиргаа, өөрөө удирдах байгууллагын нийт 260 хүн	7 чиглэлийн байгууллага, салбарын 260 ажилтан, мэргэжилтэнд нийт 36 цагийн хичээл сургалт явуулав.
					Ховд аймгийн Булган сумын ХЭХЗХ-д хамаарах 5 сумын төлөөлөл цагийн хичээл, семинарыг явуулав. Аймгийн ХЭХЗХ ны болон Ажлын албаны ажилтнуудад зориулсан хичээл, сургалт	Булган суманд 30 хүн хамрагдсан 8 цагийн, аймгийн ХЭХЗХ ны болон Ажлын албаны 20 ажилтан нийт 50 хүн 16 цагийн сургалт явуулав.
					Өвөрхангай аймгийн Хархорин сумын ХЭХЗХ ны нийгмийн ажилтнуудын	Хамаарах 7 сумын нийгмийн ажилтнууд 16 цагийн хичээлд хамрагдав.
					Завхан аймгийн сумдын ХТЗ, Хамтарсан баг, Тосонцэнгэл	Нийт 300 хүн 3 цагийн сургалт,

					сумын ХЭХЗХ ны гишүүдийн 3 цагийн сургалт, семинар	хэлэлцүүлэгт хамрагдсан.	
2.9	Дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч нарт бага насны охидын үзлэгийн талаар сургалт зохион байгуулах (ГБХТХ-ийн 15.1.4)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр)	ШШЕГ	ГХУСАЗЗАА, ЭМЯ	Эрүүл мэндийн яамнаас Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё" сэдэвт өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын нээлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган төвийн ерөнхий захирлаар батлуулж, төлөвлөгөөний дагуу 5 удаагийн сургалт зохион байгуулж, 985 албан хаагчийг хамрууллаа. Тухайлбал, Эрүүл Мэндийн Яам, Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв хамтран хэрэгжүүлж буй "Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё" сарын ажлын хүрээнд нийслэлийн дүүргүүдийн Эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн кабинетын эмч, сувилагч нар, нийслэлийн өсвөр үеийнхний төлөөлөл охид, хөвгүүдийг урьж, нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулагдсан. Өсвөр насныхны дуу хоолой болж, нийслэлийн ерөнхий боловсролын 102-р сургуулийн 12-р ангийн сурагч Д.Төгсбаяр "Эрүүл мэндийн орчин дахь хүүхдийн эрх хамгааллын хэрэгжилт" сэдвээр, 28-р сургуулийн 12-р ангийн сурагч Х.Мөнх-Эрдэнэ "Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд" сэдвээр, 51-р сургуулийн 11-р ангийн сурагч Б.Хулан "Эрүүл зөв хооллолт" сэдвүүдээр илтгэл танилцуулсан. "Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё" сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг нийт 4 удаа зохион байгуулж, 600 өсвөр үеийнхэн, 2025 оны 04-р сарын 27-нд Дундговь аймгийн төвийн 12-17 насны 100 өсвөр насныхан хамрагдсан сургалт зохион байгуулав. Мөн 2025 оны 04-р сарын 16-нд НЕБ-ын 34-р сургуулийн 9-р ангийн 243 сурагчид ЭХЭМҮТ-ийн Өсвөр үеийн клиникийн тасгийн эмч Г.Оюундарь, Нэгдсэн лабораторийн тасгийн эмч АУ-ны магистр		100

					Г.Гэрэлмаа, лаборант Э.Дөлгөөн нар сургалт зохион байгуулав. Сургалтаар "Өсвөр үеийн бэлгийн бойжилт, нийгэм сэтгэл зүйн эрүүл мэнд, тулгамдсан асуудал", "Өсвөр үеийнхний бэлгийн боловсрол, биеийн болон сэтгэл санааны хүчирхийлэл, урьдчилан сэргийлэлт", "Өсвөр үеийнхний хорт бодисын хэрэглээ, донтолт. Хоол тэжээл ба хөдөлгөөний ач холбогдол" сэдвүүдээр мэдээлэл зөвлөгөө өгсөн. 2025 оны 04 сарын 22-ны өдөр ЭХЭМҮТ-д мэргэшил олгох, дээшлүүлэх төгсөлтийн дараах сургалтанд суралцаж буй 22 сувилагчид "Өсвөр үеийнхэнд тулгамдаж буй эрүүл мэндийн асуудлууд" сэдвээр ӨҮК-ийн эрхлэгч М.Мөнххишиг сургалт явуулав. 2025 оны 4 сарын 21-нд Монголын Хүүхдийн Зөвлөлийн 20 сурагчийг хамруулан Өсвөр үеийнхэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн зөвлөгч бэлтгэн, тэдний дуу хоолойгоор дамжуулан нөлөөллийн үйл ажиллагаа явуулах 5 цагийн сургалт зохион байгуулав. Шүүх шинжилгээний байгууллагаас Монголын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын холбооноос зохион байгуулагдсан “Бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж үйлчилгээ” сэдэвт төгсөлтийн дараах хөтөлбөрийн хүрээнд Шүүх эмнэлгийн амбулаторийн тасгийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа Б.Сарангэрэл 2025 оны 03 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд “Биеийн ерөнхий болон бэлэг эрхтний үзлэг, пиктограмм, баримтжуулалт” сэдэвт сургалт зохион	
--	--	--	--	--	---	--

					байгуулсан бөгөөд тус сургалтад 9 дүүргийн 16 эмч хамрагдсан.	
2.10	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох сургалт зохион байгуулах (ГБХТХ-ийн 14.1.2)	Сургалтын тоо Оролцогчдын тоо (хүйсээр)	ЦЕГ	БЯ, ЭМЯ, ССАЖЗЯ	Эрүүл мэндийн яамнаас Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зорилгоор Боловсролын сайдын 2024 оны 10 сарын 15-ны өдрийн А/140 дугаар "Боловсролын сургалтын байгууллагын орчинд электрон тамхи хэрэглэхийг хориглох тухай" тушаал гарсан. Боловсролын ерөнхий газраас тушаалын хэрэгжилтийн тайланг улирал тутамд авч хяналт тавин ажиллаж байна. Никотин агуулсан бүх төрлийн утаат болон утаагүй бүтээгдэхүүний хор хөнөөл болон тамхидалтыг бууруулах нөлөөллийн ажлын хүрээнд Ирээдүйгээ бүү сор нэртэй шинэ пэйж хуудас нээн ажиллаж байна. Пэйж хуудсанд нийт 14 постер мэдээлэл сурталчилгааны материал, 5 төрлийн зорилтот бүлэгт чиглэсэн видео шторк, 15 рийл бичлэг байршуулсан. НЭМҮТ нь Эрүүл оюутан- Эрүүл ирээдүй аяны хүрээнд Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд М Банк Арена, Монголын Оюутны Сагсан бөмбөгийн Эрүүл ирээдүй" холбоотой хамтран "Эрүүл оюутан уриатай эрүүл мэндийн өдөрлөгийг хоёр удаа зохион байгууллаа. Өдөрлөгүүд нь үндэсний дээд лиг болон оюутны лигийн нээлтийн үеэр өргөн хүрээнд явагдаж, оюутан залуусын дунд эрүүл амьдралын хэв маяг, хорт зуршлаас татгалзах хандлагыг дэмжихэд чиглэсэн олон арга хэмжээг багтаасан. Оюутнуудыг тэмцээнд оролцуулах замаар тамхинаас татгалзах уриаг лалүүлэх, "Соёлтой залуус үгүй гэж хэлдэг спортыг сонгоё" гэсэн гол концептыг сурталчилж, оюутнуудыг эрүүл спортоор хичээллэх, эрүүл амьдралын хэв маягийг эрхэмлэхэд уриалсан.	100

					Мөн өдөрлөгийн хүрээнд нийтдээ 7 видео рийл бичлэг бэлтгэж, Олон нийтийн сүлжээгээр сурталчилгаа, мэдээллийг түгээн, оюутан залуусын оролцоог нэмэгдүүлсэн. дүүлсэн. М Банк Арена дахь дөрвөн талдаа байрласан том электрон дэлгэц ашигласан дэлгэцээр оюутнуудыг чиглүүлэх зорилгоор "Электрон тамхины худал мэдээлэл, бодит байдал" сэдвээр мэдээллийн бичлэг гаргаж, оюутнуудад үнэн бодит мэдээллийг хүргэж, тамхи хэрэглэхгүй байх хандлагыг бэхжүүлэхэд чиглүүлсэн. Үе тэнгийн сургагч багш нарыг чадавхжуулах сургалтыг Ерөнхий боловсролын Гете сургуулийн ахлах болон дунд ангийн нийт 25 суралцагчдад "Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хор уршиг", "Дэлгэцийн донтолт" сэдвээр сургалт зохион байгуулж үе тэнгийн сургагч багш, клубын идэвхтэн хүүхдүүдийн мэдлэг мэдээллийг дээшлүүлсэн. Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд ШУТИС, Дотоод хэргийн их сургууль. МУИС-ийн нийт 3000 гаруй оюутанд бүх төрлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний хор нөлөө, тамхинаас үүдэлтэй өвчлөл сэдвээр нийт 8 удаагийн сургалт зохион байгуулж, 3025 сурагчийг хамрууллаа. ССАЖЗЯ-аас "Сайн дурынхны байгууллагуудын сүлжээ" ТББ, "Амгалан айл" ТББ-тай хамтран 21 аймгийн Залуучуудын хөгжлийн төвүүдэд 2025 оны 03 дугаар сарын 20-оос 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд "Good deeds day" сайн үйлсийн өдрийн 1 сарын аяныг зохион байгуулж Аяны хүрээнд 13 аймаг, 4 дүүргийн нийт 2,744 төрийн болон төрийн бус	
--	--	--	--	--	---	--

				байгууллагын ажилтан нар Ерөнхий боловсролын сургуулиудад нийт 22,907 өсвөр үе, хүүхдүүдийг хамруулж хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох сургалт зохион байгуулж ажилласан. Тус үйл ажиллагааны зохион байгуулалтын талаарх мэдээ, мэдээллийг хүргэх цахим уулзалтыг 21 аймгийн Залуучуудын хөгжлийн төвийн албан хаагчдад 1 удаа зохион байгуулсан. 2020 оноос Гэр бүл, хүүхэд залуучуудын газар болон түүний харьяа орон нутгийн Залуучуудын хөгжлийн төвүүд энэхүү дэлхийн хөдөлгөөнд нэгдэж, улмаар жил бүрийн 4-р сард МУ-ын 21 аймаг, 9 дүүргийн залуучууд орон даяар “Сайн үйлсийн өдөр”-ийн аянд идэвх санаачилгатай оролцдог болсон. 2025 онд Сайн үйлсийн сарын аянд 13 аймаг, 6 дүүргийн нийт 2,744 сайн дурынхан 18,665 цаг ажиллаж, 143 сайн үйлсийн санаачлагыг өрнүүлж, нийтдээ 560 байгууллага, 22,907 хүнийг хамруулан ажиллаа. 2026 оныг “Тогтвортой хөгжлийн төлөөх сайн дурынхны олон улсын жил” болгон тэмдэглэн өнгөрүүлэхийг угтан 2025 оны 06 сарын 26-ны өдөр Нэгдсэн үндэсний байгууллагын байранд "САЙН ДУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨХ УРИАЛГА" үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Цагдаагийн байгууллагаас Өсвөр насны хүүхдүүд гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэлийг бууруулах, мансууруулах бодис, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Залуусын манлайлал” төрийн бус	
--	--	--	--	---	--

					байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй “Цонхоо нээ-1” төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 102, 152, 62, сургуулиудын нийт ахлах бүлгийн 1110 сурагчдад жүжигчилсэн тоглолт, сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. "Хуулиа мөрдье" нэгдсэн арга хэмжээний хүрээнд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн болон хохирсон хэргүүдийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, архи согтууруулах ундааны хор уршгийн талаар "Өдрийн сонин"-д нийтлэл хэвлүүлсэн. Ерөнхий боловсролын “Шинэ эрин”, “Шинэ Монгол Харүмафүжи” 70 дугаар сургууль, “Үй цай” зэрэг сургуулиудын 5-12 дугаар ангийн 2050 сурагчдад Үе тэнгийн дээрэлхэлт, “Цахим донтолт”, “Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх” сэдвээр сургалтуудыг үе шаттай зохион байгуулсан. Цагдаа дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвд олон нийтийн цагдаагийн сургалтад хамрагдаж байгаа 60 хүнд “Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сэдвээр тус тус сургалт зохион байгуулсан.Цаашид Урьдчилсан сэргийлэх албаны Хүүхдийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтэстэй гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн талаар харилцан мэдээ мэдээлэл солилцон, хамтран арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас өсвөр насны хүүхэд, оюутан, залуучуудыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдож, хохирохоос урьдчилан сэргийлэх	
--	--	--	--	--	--	--

				зорилгоор “Анзаар-2” аяныг энэ оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс энэ оны 06 дугаар сарын 15-ны хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Уг аяны хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 5 сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа ахлах сургууль, Баянгол дүүргийн 10 дугаар хорооны эрсдэлт бүлгийн насанд хүрээгүй 6425 сурагчдад “Хорт зуршил ба донтолт” сэдэвт 48 удаагийн, их, дээд сургууль, коллежийн 1002 оюутан, төрийн 6, төрийн бус 18 байгууллагын 1541 ажилчдад “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагавар, хууль эрх зүйн хариуцлага” сэдэвт 24 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сэрэмжлүүлэг, уриалга бүхий 34 видео, 16 төрлийн постер, 13 рийл нийт 63 мэдээ, мэдээлэл байршуулахад давхардсан тоогоор 4.5 сая хэрэглэгчдэд хүрсэн. Мөн газраас Боловсролын ерөнхий газартай хамтран Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 34 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарыг “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургагч багшаар бэлтгэх сургалтыг энэ оны 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангахад эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхний дунд гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөх, оролцох эрсдэлийг бууруулах,	
--	--	--	--	--	--

					өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хамгаалах дадлыг төлөвшүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “365 анхаарч, хайрлая” уриатай мэдээлэл, нөлөөллийн ажлыг энэ оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөө, ажлын чиглэл, дүгнэх хүснэгт боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргаар батлуулж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг хангаж, энэ оны 12 дугаар сарын 08-ны өдрин 18/2656 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулсан. Уг арга хэмжээний хүрээнд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас хүүхдийг хорт зуршлаас урьдчлан сэргийлэх чиглэлээр 517 удаагийн сургалтыг зохион байгуулж, ерөнхий боловсролын 94905 сурагч, 32091 иргэнийг хамруулсан. УЕПГ-ын харьяа прокурорын газрууд, хүүхдийн эсрэг болон хүүхэд хохирсон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийн талаар хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд таниулан сурталчлах, тэдгээрийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор, “Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт”, “Цахим орчны зохистой хэрэглээ”, “Үе тэнгийн дээрэлхэлт, хор уршиг”, “Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” “Хүүхэд хамгаалал”, “Гэр бүлийн хүчирхийлэл” зэрэг сэдвүүдээр Олонлог төв болон Нийслэлийн 75, 7, 15, 5, 21, 33, 39, 57, 17, 49, 84	
--	--	--	--	--	--	--

					дүгээр сургууль, Өмнөговь аймгийн Ханбогд Даланзадгад, Гурвантэс, Ноён, Хүрмэн, Номгон сум, Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5 дугаар сургууль, Хэрх ерөнхий боловсролын сургууль, Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль, 18 дугаар сургууль, Хонгор сумын ерөнхий боловсролын 14 дүгээр сургууль, ийн сургуулийн багш, сурагчдад тус тус сургалтыг зохион байгуулсан байна. Түүнчлэн Дархан-Уул аймгийн прокурорын газар 5 их, дээд сургуулийн оюутнууд, ерөнхий боловсролын 8 сургуулийн ахлах ангийн нийт 2300 гаруй хүүхдүүдэд 15 удаагийн сургалтыг, Хэнтий аймгийн прокурорын газар 1, 2, 4 дүгээр сургуулийн багш, ажилтан, сурагч, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 29, ерөнхий боловсролын сургуулиудын 31, эрүүл мэндийн газрын 10, нийт 70 нийгмийн ажилтанд, Сэлэнгэ аймгийн прокурорын газар “Хүүхэд холбогдсон болон хохирсон гэмт хэрэг, зөрчилд нөлөөлж буй хүчин зүйл” сэдэвт хэлэлцүүлэг, Өмнөговь аймгийн прокурорын газар “Зодохгүй, хайраар хүмүүжүүлье” сэдэвт тэмцээнийг, Багануур дүүргийн прокурорын газар “Хүүхдийн эрх-Бидний үүрэг” нэгдсэн аяныг Баянхонгор аймгийн прокурорын газар “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”- ийн 9 сургуулийн 9 бүлгэмээс Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан үе тэнгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бусдад эергээр нөлөөлөх богино хэмжээний контент 9-ийг бэлтгэж, Говьсүмбэр аймгийн прокурорын газар “Хүний эрх хүүхдийн эрхээс эхэлнэ” сэдэвт аяныг, ерөнхий боловсролын I, II, V сургуулиудын 6-8 дугаар ангийн 200 гаруй сурагчдад “Хүүхдийн	
--	--	--	--	--	---	--

				эрх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалтыг тус тус зохион байгуулсан байна. УБЕГ, Нийслэлийн Багануур дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр болон Монгол цэргийн өдрийг тохиолдуулан 2025 оны 03 дугаар сарын 03-наас 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд жендерийн тэгш бус байдал, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 16 насанд хүрч иргэний үнэмлэхээ захиалахаар ирсэн хүүхдүүдэд жендерийн тухай ойлголтын талаар мэдээлэл хүргэн ажилласан. Нийслэлийн Багахангай дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эцэг, эхийн зөвлөлөөс тус дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэстэй хамтран "Гэр бүлийн хүчирхийлэл, түүний мөн чанар" сэдвээр өсвөр насны хөвгүүдийг хамруулсан сургалт зохион байгуулсан. Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс тус дүүргийн Хууль, эрх зүйн хэлтэс, Нийслэлийн ерөнхий боловсролын 62,12,9,76,67-р сургуулиудтай хамтран багш, сурагч, эцэг эхчүүдэд хууль, эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэгт өртөж болзошгүй үед урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрхэн авах, эцэг, эхчүүдээс хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах, цахим тоглоомд донтох, гэмт хэрэгт өртөхгүй байх орчныг бүрдүүлэх, архи, тамхины хор уршгаас урьдчилан сэргийлэх	
--	--	--	--	--	--

					зорилгоор 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас бага насны хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд соёлтой зөрчилгүй оролцох, аюул ослоос сэрэмжлүүлэх, эцэг эх, хамаарал бүхий хүмүүс нөлөөлөгч байх түүнчлэн Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхахгүй байх, хэрхэн ойлгож туслах талаар мэдлэг ойлголт өгөх зорилгоор "Олуулаа" сургуулийн 5, 6-р ангийн 80 сурагчдад 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр, Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 7, 8-р ангийн 70 сурагчдад 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр тус сургуулиудын багш, нийгмийн ажилтнуудтай хамтран зохион байгууллаа. Дотоод хэргийн их сургуулиас Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын тусгай хэрэгцээт 55-р сургуулийн 27 сурагчид эрх зүйн мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа.	
2.11	Өсвөр насны хүүхдийн нийгэмшихүйг дэмжих гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчид зориулсан гарын авлага боловсруулах	Боловсруулсан гарын авлага	МХЭССХ	ХГБХХЕГ	Монголын хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэнгээс өсвөр насны хүүхдийн нийгэмшлийг дэмжих үйлчилгээний байдалд хийсэн дээрх үнэлгээний үр дүнд үндэслэн "ЗӨВХӨН ТАНД" нэртэй аав ээж, асран хамгаалагчийн гарын авлагыг боловсруулж, хууль зөрчсөн хүүхэд, тэдний эцэг эх, гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, асран хамгаалагчид танилцуулж, хичээл, зөвлөгөө өгч, цаасаар хэвлэж ашиглаж туршиж байна. Энэхүү гарын авлага нь эцэг эх, асран хамгаалагч, боловсрол, нийгмийн халамж,	100

					хамгааллын үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтнүүдэд чиглэсэн бөгөөд хүүхдийн хөгжлийн онцлог, зан үйлийн асуудлыг ойлгох, зөв харилцах, дэмжлэг үзүүлэх, зөрчил дахин гарахаас сэргийлэхэд практик арга зүйгээр хангах зорилготой. Гарын авлагын ач холбогдол •Хүүхдийн зан үйлийн асуудлыг зөв ойлгож, буруу хариу үйлдлээс зайлсхийхэд дэмжлэг үзүүлнэ. •Эцэг эх болон мэргэжилтнүүд хүүхэдтэй зөв харилцах, сэтгэлзүйгээр дэмжих практик арга барил эзэмшинэ. •Хүүхдийн хөгжлийг цогц байдлаар авч үзэж, эрсдэлийг тодорхойлж урьдчилан сэргийлэх арга замыг системтэй хүргэнэ. •Зөрчил, үл ойлголцол, стресс, буруу нөлөө, цахим орчны эрсдлийн үед баримтлах тодорхой зөвлөмжтэй. •Хүүхдийн эрхийг хүндэтгэх, орчин үеийн эцэг эхчлэл, эерэг хүмүүжилд тулгуурласан шийдлийг санал болгодог.	
2.12	“Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” теле хичээл бэлтгэж, түгээх (ХХтХ-ийн 25.2)	Бэлтгэсэн теле хичээл Түгээсэн хэлбэр, тоо	ХХЗХ	-	Харилцаа холбооны зохицуулах хорооноос НҮБ-ын Хүүхдийн Сан, ТЭСО групптэй хамтран “Цахим орчинд хүүхдээ хамгаалъя” төслийн хүрээнд хүүхдэд зориулсан 13 (6-10 насны хүүхэд 3, 11-14 насны хүүхэд 5, 15-18 насны хүүхэд 5), эцэг эх, асран хамгаалагчид зориулсан 5, багш, сургалтын ажилтнуудад зориулсан 5, нийт 23 хичээлтэй сургалтын багц модул боловсрууллаа. Уг сургалтын багц модуль тус бүрээр теле хичээл бэлтгэлээ. Сургалтын багц модулийг таниулах арга хэмжээг ерөнхий боловсролын 2 сургууль дээр зохион байгуулна. Арга хэмжээнд хүрээнд	100

					бэлтгэсэн сургалтын сурагчид, эцэг эх болон багш суран хүмүүжүүлэгчдэд таниулах сургалтыг зохион байгуулна.	
2.13	Өсвөрийн сэргийлэгч-2025 уралдааныг зохион байгуулах (ГХЗУСтХ-ийн 10.2.6)	Зохион байгуулсан арга хэмжээ, Оролцогчдын тоо (хүйсээр)	ГХУСАЗЗАА	Дэд зөвлөлийн гишүүд	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7, 10 дугаар зүйлийн 10.2.6, 10.2.7 дахь заалт, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4.7 дахь заалтад заасныг үндэслэн “Өсвөрийн сэргийлэгч-2025” аймаг, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар удирдамжийн төслийг боловсруулсан 21 аймгийн ГХУСАЗСЗ-д хүргүүлсэн. Аймгууд 2025 оны 05 дугаар сард багтаан аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг дараах хуваарийн дагуу зохион байгууллаа. 1.Хангайн бүс (Архангай, Өвөрхангай, Баянхонгор) 2025.05.09-нд 2. Баруун бүс (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд) 2025.05.28-нд, 3.Хойд бүс (Булган, Орхон, Хөвсгөл) 2025.05.28-нд, 4.Төвийн бүс (Дархан-Уул, Сэлэнгэ, Төв) 2025.05.27-нд, 5.Зүүн бүс (Дорнод, Сүхбаатар, Хэнтий) 2025.05.09-нд,	100

					6.Говийн бүс (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) 2025.05.09-нд тус тус зохион байгуулав.	
2.14	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээ	Дэд зөвлөлийн гишүүд		Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга, НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгч нарын 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хамтран ажиллах төлөвлөгөө, 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн шинэчлэн баталсан төлөвлөгөөний дагуу Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Тусгай тайланг хавсаргав.	100
2.15	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хийж буй ажил, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг www.familycenter.mn цахим хуудаст тогтмол оруулж, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх (ГБХТХ-ийн 11.1.2, ГХЗУСТХ-ийн 10.2.3)	Нийтэлсэн мэдээлэл	ГХУСАЗЗАА	Дэд зөвлөлийн гишүүд	ГХУСАЗЗАА-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн www.cccp.gov.mn www.familycenter.mn цахим хуудас болон фэйсбүүк, инстаграм, ютүб сувагт 2025 онд нийт 65 контент, 58 рийл бичлэг оруулж, нийтэд түгээлээ. Улсын дээд шүүхээс Хүчирхийллийн аливаа хэлбэр нь хүүхдийг хүмүүжүүлэх арга биш, Бага насны хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан ялыг хэвээр үлдээв тойм бэлтгэж, олон нийтэд түгээв. Түүнчлэн Иргэдийн эрх зүй, шүүхийн мэдлэгийг дээшлүүлэх "Шүүхийн боловсрол" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах 131 контентыг нэвтрүүлэг, постер, зураг, бичлэг, нийтлэл, анимейшн хэлбэрээр хүргэсэн байна. Үүнд: 1.Шүүхийн цаг нэвтрүүлэг нийт 12 дугаар: 2.Шүүхийн шийдвэрийн хувилбараар нийт 72 дугаар; тоймыг аудио	100

				3."Мэдэхэд илүүдэхгүй" цуврал контентын 3 видео, 2 постер мэдээлэл; 4."Бид юу хийдэг вэ" цуврал контент 3 дугаар; 5."Шүүгчийн алх", "Шүүгчийн нөмрөг" богино видео контент 2; 6.Шүүхийн шийдвэрийн тойм 34; 7.Шууд дамжуулалттай холбоотой мэдээлэл. Мөн оюутан, сурагчдад шүүхийн үйл ажиллагаатай танилцуулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургуулийн 307 оюутан, сурагч хамрагдсан уулзалтуудыг зохион байгуулсан. Цагдаагийн байгууллагаас Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 25 мэдээлэл бэлтгэн www.familycenter.mn цахим хаягт байршуулан хамтран ажиллаж байна. Тухайлбал: Хүчирхийллийг хүн бүр мэдээлэх үүрэгтэй, Гэр бүлийн харилцаанд бухимдал хэрэггүй, Гэр бүл гэдэг хүчирхийллийн орон зай биш, харин хайр, хүндлэл, ойлголтын орчин байх ёстой, Гэр бүлийн харилцааг эерэг байлгах үр дүнтэй аргууд, Гэр бүлийн маргаанд ялагч гэж байхгүй, Хүндлэл байгаа орчинд хүчирхийлэл байдаггүй, Гэр бүлийн аз жаргалтай харилцааны нууц, Гэр бүлийн хүчирхийллийн дам хохирогч нь хүүхэд, Гэр бүлийн асуудлаа ярилц, учирлаж ярилцсан хоёрын дунд ухаарал, үнэн хоёр үлддэг зэрэг нийт 25 зурагт постерыг байршуулсан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын байгууллагаас салбарын үйл ажиллагаа, хүүхэд хамгаалал, хөгжлийн бодлого, хэрэгжилтийг сурталчлах ажлын хүрээнд 320 мэдээ, постер,	
--	--	--	--	---	--

				121 видео контент, рийл бэлтгэж, байгууллагын олон нийтийн сүлжээгээр сурталчилж, давтагдсан тоогоор 3,2 сая хандалт авч ажилласан. Үүнээс: -Салбарын хууль, тогтоомж сурталчлан таниулах хүрээнд 66 постер, 71 видео контент, 2 2D анимейшн, -Мэдээлэл, зөвлөмж, хууль олон нийтэд таниулах 154 мэдээ, сурвалжилга, -Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зөвлөмж хүргэсэн 84 постер, 40 видео контент, -Гэр бүлийн боловсрол олгох 4 цуврал нэвтрүүлэг, -Тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан нөлөөллийн үйл ажиллагаа өрнүүлэх, сурталчлах ажлын хүрээнд 50 рийл, видео контент хийж ажилласан. ШШЕГ, Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын Шүүх эмнэлгийн амбулаторийн тасагт 943 бэлгийн холбогдолтой шинжилгээг хүлээн авч дүгнэлт гаргасан байна. Үүнээс 0-3 насны 4, 4-7 насны 17, 8-12 насны 38, 13-17 насны 283 хүүхэд бэлгийн холбогдолтой шинжилгээ хийлгэсэн байна. Тус газарт 2025 онд нийт 56 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлсэн ба эрэгтэй-30, эмэгтэй-26 насанд хүрэгч-54, хүүхэд-2 байна. Үүнээс: 1.Хүний эрүүл мэндэд хохирол учирсан-41, 2.Зам тээврийн ослын улмаас үүдэн хүний амь нас, эрүүл мэндэд учирсан-8, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг-4, Гэр бүлийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн-3 байна.	
--	--	--	--	--	--

					Мөн үйлчлүүлэгчдийнхээ тулгамдаж буй асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх, тэдний нэр төрийг хамгаалах, нууцлалыг хангах, сэтгэл зүйн байдлыг анхаарч цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллаж байна. Байгууллагын хэмжээнд “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэл”-ээр хийж буй ажил, арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг www.familycenter.mn цахим хуудаст оруулахаар бэлтгэж байна. Хууль зүйн туслалцааны төвөөс өмгөөлөгчийн үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд “Улсын өмгөөлөгч зөвлөж байна” цуврал рийл контентоор “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” сэдвээр 1 рийлийг бэлтгэн, www.familycenter.mn цахим хуудсаар олон нийтэд түгээв.	
2.16	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль зүйн мэдээ мэдээллийн рийл, контент бэлтгэж олон нийтэд түгээх (ГБХТТХ-ийн 11.1.2)	Түгээсэн мэдээлэл	ХЗҮХ	ХХЗХ	ХЗҮХ-ээс “Гэр бүлийн хүчирхийлэл”, “Хүүхдийн тэтгэлэг тогтоолгох, төлүүлэх” сэдэвт подкаст, “Хүчирхийлэлд өртсөн хүний ойлгох чадвар буюу эмпати нь асар их хөгжсөн байдаг”, “Гэр бүлийн нэр төлөө хадгалахын тулд эмэгтэйчүүд гэмт хэргийн хохирогч болж байна” сэдэвт рийлс бүтээж, түгээсэн. Харилцаа холбооны зохицуулах хрооноос ЦХИХХ-ын сайд, ХЗДХ-ийн сайд, ГБХНХ-ын сайд нар хамтран 2025.03.28-ны өдрийн А/53, А/95, А/76 тоот тушаалаар “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ыг баталсан. Уг журам баталсантай холбогдуулан цахим орчинд хүүхдийг хориотой	100

					болон хүүхдэд агуулгаас хамгаалах зохицуулалтын талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор 1 подкаст, 3 рийлсийг ХЗҮХ-тэй хамтран бэлтгэж, байгууллагын веб сайт, пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд түгээсэн. УЕПГ-аас “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн шийдвэрийн хууль зүйн үндэслэл, “Хүүхэд хохирсон, холбогдсон зөрчлийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан нөхцөл”-ийг судлах, судалгаагаар тогтоогдсон нөхцөл байдалд дүгнэлт хийж, цаашид анхаарах асуудлын талаар болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг зөрчил болон хүүхдийн эсрэг гэмт хэрэг хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга уулзалт хэлэлцүүлэг хийх зэрэг нөлөөллийн арга хэмжээ авч ажиллах талаар харьяа прокурорын газруудад 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 4/01, 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр №06 дугаартай мэдээллийг нэгж прокурорын газарт хүргүүлсэн. Тус мэдээллийн мөрөөр, харьяа прокурорын газрууд, дараах ажил арга хэмжээг авч ажиллажээ. Тухайлбал, Аймаг, нийслэл, дүүрэг, сумдын прокурорын газруудаас хүүхдийн эсрэг болон хүүхэд хохирсон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх, хүүхдийн эрхийн талаар хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд таниулан сурталчлах, тэдгээрийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх	
--	--	--	--	--	---	--

					зорилгоор шалгалт 8, судалгаа 15 хийж, сургалт 62, видео контент, өдөрлөг, яриа танилцуулга 32 удаа зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар прокурорын 30 мэдэгдэл хүргүүлж, хариуг авч ажилласан байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс Гэр бүлийн хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэл болон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр олон нийтийн эрх зүйн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллага нь 2025 онд сошиал медиа, телевиз, радио, мэдээллийн сайтууд зэрэг нийтэд хүрэх сувгуудыг ашиглан хууль сурталчлах ажлыг өргөн хүрээнд зохион байгууллаа.Энэхүү үйл ажиллагааны хүрээнд нийт 26 удаагийн мэдээ, мэдээлэл, ярилцлага, нийтлэл зэрэг контентыг дараах хэлбэрээр олон нийтэд хүргэв: •TV9 телевизийн шууд нэвтрүүлгээр гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэг болох тухай, түүнтэй холбоотой Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн заалтуудын талаар мэргэжлийн тайлбар, мэдээллийг хүргэсэн. •Eagle телевиз болон ТВ5 телевизийн тусгай нэвтрүүлгээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, даван туулагч эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал, тэдэнд үзүүлэх дэмжлэг туслалцааны боломж, төр болон ТББ-уудын үүрэг, хамтын ажиллагааны талаар ярилцлага, зөвлөмж хэлбэрээр мэдээлэл өгсөн. •Зөгий.мн мэдээллийн сайтад “Хүчирхийллийг зөвтгөж болохгүй — Гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэг” сэдвээр нийтлэл, мэдээлэл байршуулсан.	
--	--	--	--	--	--	--

					•UBS, TV8, Монголын үндэсний олон нийтийн телевиз (MNB) зэрэг гол мэдээллийн сувгуудаар дамжуулан гэр бүлийн хүчирхийлэл, сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах асуудлаар мэргэжлийн байгууллагын байр суурь, судалгаанд үндэслэсэн зөвлөмжийг олон нийтэд хүргэсэн. •Interview сэтгүүл, Монголын радио, бусад олон нийтийн цахим сайтуудаар гэр бүл дэх хүчирхийллийн хор уршиг, хүүхдийн хөгжилд үзүүлэх сөрөг нөлөө, хүчирхийллийн таслан зогсоохын тулд авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаар мэдээлэл өгсөн байна. •Тэнгэр телевизийн “Хүүхэд хөгжил ба хамгаалал” сэдэвт нэвтрүүлэгт хоёр удаа оролцож Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдэд хэрхэн нөлөөлж байгаа, хуулиар хүүхэд хамгаалагдаж чадахгүй, хүүхдийн эрх зөчигдөж байгаа талаар мэдээлэл өгсөн. •Монгол HD телевизийн олон нийтэд чиглэсэн, нийгмийн тулгамдсан асуудлыг хэлэлцдэг “Нүүдэл-Шийдэл” нэвтрүүлэгт манай төвийн сэтгэл зүйч оролцож, “Гэр бүлийн дэх хүүхдийн эрх” сэдвийн хүрээнд мэргэжлийн үзэл бодол, мэдлэг, туршлагаа хуваалцсан.Сэтгэл зүйчийн зүгээс хүүхдийн эрх зөрчигдөх үед үүсдэг сэтгэл зүйн хохирол, түүний урт хугацааны үр нөлөө, хүүхдийн хөгжлийн явцад үзүүлэх нөлөөллийн талаар мэргэжлийн үндэслэлтэй тайлбар хийж, үзэгчдэд ойлгомжтой байдлаар мэдээлэл хүргэсэн. •MYONTV Нээлттэй хэлэлцүүлэг гэр бүлийн хүчирхийллийн сэдвээр хэлэлцүүлэгт оролцлоо	
--	--	--	--	--	--	--

2.17	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэж буй аливаа контент, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байдлаар бэлтгэж, түгээх (ХБХЭтХ-ийн 6.3.2)	ХБИ-нд хүртээмжтэй түгээсэн мэдээлэл	ХБХХЕГ	Дэд зөвлөлийн гишүүд	ГБХНХЯ-аас Хүүхэд хамгааллын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээг олон талт, хамтарсан арга хэмжээ, зорилтот бүлэгт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ гэсэн төрлөөр зохион байгуулсан. Үүнд: -Эхний хагас жилийн байдлаар хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажилласан. Тухайлбал, Хамтдаа шалгая, хамгаалъя, Цахим орчныг соёлтой хэрэглэе, Хүүхэд-хайр-ирээдүй, Харилцан хүндэтгэе зэрэг 160 гаруй аян, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 109,950 хүүхэд, 99,799 эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулсан. -Гэр бүлийн орчинд хүүхэд хамгааллыг сайжруулах, эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийтэд хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, Сайн эцэг эх байх зарчим, Гэр бүлийн харилцаа, Гэр бүлийн баяр хөөр, Гэр бүл төлөвлөлт зэрэг 43 удаагийн сургалт, 15 аян, 4 нэвтрүүлэг, 2 зөвлөгөөн, 10 өдөрлөг зохион байгуулсан байна. Тус арга хэмжээнд 43404 хүүхэд, 101,447 эцэг, эх асран хамгаалагчийг хамруулсан. -Зорилтот урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд, түүний гэр бүлд чиглэсэн 20 удаагийн сургалт, 37 нөлөөллийн арга хэмжээ, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, шаардлагатай үйлчилгээг үзүүлэх зорилгоор гэрээр айлчлах хөтөлбөрийг 4 аймаг	100
------	--	--------------------------------------	--------	----------------------	--	-----

				хэрэгжүүлсэн. Гэр бүлийн боловсрол, гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчдад чиглэсэн гэр бүлийн харилцаа, боловсрол, төлөвлөлт, уралдаанч хүүхдийн эрх хамгаалал, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдож, хохирохоос урьдчилан сэргийлэх зэрэг зорилтот урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил 3, өдөрлөг 4, зөвлөгөөн 3 тус тус зохион байгуулсан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр бэлтгэсэн 2 видео зөвлөмжийг текстэн тайлбартай бэлтгэн олон нийтэд түгээсэн. Мөн “Цахим орчинд хүүхдээ хамгаалъя” төслийн хүрээнд хийгдэх багц сургалтын модулийн видео хичээлүүдийг текстэн болон дохионы хэлний болон текстэн тайлбартай хийлээ. Хүүхдийн оролцоог хангах чиглэлээр ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын зохион байгуулж буй “Эерэг цахим ирээдүй” видео контент бүтээх хакатонд 29-р сургуулийн хэл ярианы бэрхшээлтэй 3 сурагчаас бүрдсэн “Харагддаг дуу хоолой” багийг хамруулж, цахим орчинд орчинд хүүхэд хамгааллын талаар сургалт мэдээлэл өгсөн. Хакатоны эхний шатны шалгаруулалтад уг баг шалгарсан бөгөөд 2-р шатны шалгаруулалтад ирүүлсэн видео контентыг “Цахим орчны хүүхэд хамгаалал” пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж байна. Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр мэдээ,	
--	--	--	--	--	--

					мэдээллийг бэлтгэн хүргэдэг “Амрыг эрье” нэвтрүүлгийг иргэдэд хүртээмжтэй хүргэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлаж дохионы хэлмэрчийн орчуулгатайгаар Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз болон төв орон нутгийн бусад телевизээр дамжуулан мэдээллийг түгээн ажиллахаар “Дохионы хэлмэрч”-тэй “Хамтран ажиллах гэрээ”-г 1 жилийн хугацаатай байгуулсан. Энэ оны эхний 11 сарын байдлаар “Амрыг эрье” нэвтрүүлгийн 23 дугаарын 670 минутын багц сурвалжилга мэдээллийг дохионы хэлмэрчийн орчуулгатай бэлтгэн, төв, орон нутгийн телевизүүдээр дамжуулан иргэдэд түгээсэн. Түүнчлэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 31 төрлийн сэрэмжлүүлэг видео мэдээллийг дохионы хэлмэрчийн орчуулгатай бэлтгэн иргэд, олон нийтэд түгээсэн. Цагдаагийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээллийг хүртээмжтэй хүргэх, тэднийг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, байгууллагын үйлчилгээг ойртуулах чиглэлээр Мэдээлэл шуурхай удирдлагын төвд брайл үсэг бүхий хэвлэмэл материал байршуулсан мөн хараа, хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэдэд байгууллагын үйлчилгээний талаарх мэдээллийг дохионы хэлмэрчийн орчуулгатай хүргэсэн видео мэдээллүүдийг дэлгэц байршуулан иргэдэд түгээж байгаа талаар 3 төрлийн видео мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудаст байршуулж, иргэд олон нийтэд түгээсэн. Тус албанаас дохионы хэлмэрчийн орчуулгатайгаар бэлтгэн цахим орчинд түгээсэн	
--	--	--	--	--	--	--

				мэдээллүүд өнөөдрийн байдлаар 421,300 цахим хэрэглэгч хүрсэн хандалттай байна Мөн “Өөрийн бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадварт суралцах”, “Өөрийгөө хамгаалах чадварт суралцах” сэдвээр 6 төрөл, бага насны хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр “Аюул занал, сэтгэцийн гэмтэл дагуулсан үйл явдлын дараах хүүхдийн хариу үйлдэл, хамгаалах хүчин зүйл”, “ Аюул занал, сэтгэцийн гэмтэл дагуулсан үйл явдлын дараа илрэх үр дагавар”, “Хүүхэд бухимдлаа яаж гаргадаг вэ?”, “Хүүхдэд зүй бус хандсанаас үүсэх сөрөг үр дагавар” сэдвээр 4, нийт 12 төрлийн 250 ширхэг зөвлөмжийг зурагт хуудас хэлбэрээр бэлтгэн албаны мэдүүлэг авах өрөө, хүлээлгийн танхимд байршуулан иргэд, хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч нарт хүргэж ажилласан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын байгууллагаас гэр бүлийн боловсрол олгох чиглэлээр Гэрлэлт, гэр бүлийн тухай ойлголт, Гэр бүл төлөвлөлт, Гэр бүлийн үнэт зүйл, угийн бичиг хөтлөлт, Гэр бүлийн харилцаа, ёс зүй, Гэр бүл дэх хүүхдийн хүмүүжил, хөгжил, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, Гэр бүлийн эдийн засаг зэрэг сэдвээр цуврал хичээл бэлтгэн байгууллагын пэйж хуудас болон олон нийтийн цахим хэрэгслээр иргэд олон нийтэд түгээж ажилласан. Тус хичээлийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор дохионы хэлмэрч, доогуур бичвэр (subtitle)-тай бэлтгэн давхардсан тоогоор 58,500 хүнд хүргэсэн. Мөн хүүхэд, гэр бүлийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа томоохон	
--	--	--	--	---	--

					арга хэмжээний үед дохионы хэлмэрчийг ажиллуулсан. Тухайлбал Хүүхдийн байгууллага үүсэж, хөгжсөн 100 жилийн ойн нээлт, хаалтын арга хэмжээ, “Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулагдсан арга хэмжээний үед дохионы хэлмэрчийг ажиллуулж, иргэд, олон нийтэд мэдээллийг хүртээмжтэй байдлаар хүргэж ажилласан. Хууль зүйн туслалцааны төвөөс Хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу иргэдэд үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх тухай 2D форматаар 1,18 минутын видео контентыг дохионы хэлний орчуулгатайгаар бүтээж, байгууллагын цахим хуудас болон сошиал сүлжээгээр тогтмол түгээхийн зэрэгцээ 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн нийслэлийн “Мишээл”, “Дүнжингарав”, “Драгон”, “Баянхошуу” нэг цэгийн үйлчилгээний төвүүд болон “Малчин”, “SBN” телевизээр өдөрт 56 удаа олон нийтэд хүргэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах контентыг дохионы хэлний орчуулга, хадмал тайлбартайгаар бэлтгэх болон холбогдох байгууллагын бэлтгэсэн контентыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын фейсбүүк хуудас, байгууллагын www.gov.mn цахим сайтад байршуулж түгээн ажилласан байна. Үүнд: -ГБХНЯ, ХБХХЕГ, Humanz хамтран Хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, өсвөр	
--	--	--	--	--	--	--

					насны хүүхдийг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхахгүй байх, үе тэнгийн дээрэлхэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх талаар 1 контентыг хадмал тайлбар, дохионы орчуулгатай бэлтгэж, түгээсэн; -Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөлөөс бэлтгэсэн 2 контентод хадмал тайлбар, дохионы орчуулга нэмж түгээсэн; -Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсээс бэлтгэсэн 15 контентыг байгууллагын сошиал хуудсаар дамжуулан түгээсэн; -Нийгмийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх тухай - 7 постерийг бэлтгэж түгээсэн; -Цагдаагийн албан хаагч, Оюутнуудаар дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүнд бэрх биш ээлтэй байхыг уриалсан уриалга-7 geel (хадмал тайлбартай) тус тус түгээлээ.	
2.18	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зохистой хэрэглээний талаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах	Түгээсэн мэдээлэл	ХХЗХ	Дэд зөвлөлийн гишүүд	Харилцаа холбооны зохицуулах хорооноос Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2-т заасны дагуу цахим орчинд хүүхэд хамгаалах чиглэлээр 5 удаагийн сургалт (420 хүн хамрагдсан), 4 удаагийн төсөл арга хэмжээ, 4 удаагийн контент зөвлөмж бэлтгэлэнэ. Цахим орчинд хүүхдийн эрхийг зөрчсөн агуулгатай контент, мэдээ мэдээллийг цахим орчноос устгах, хязгаарлах чиглэлээр технологийн арга хэмжээг авч ажилласан. 1.Монгол Улсын хууль, тогтоомж, хүүхдийн эрхийг зөрчсөн агуулгатай контентыг нийтэлсэн 516 веб сайтыг хар жагсаалт /black-list.mn/-д оруулж, монгол улсын нутаг дэвсгэрээс хандах	100

					хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээг авч ажилласан. 2.Meta компанийн Facebook, Instagram платформд хүүхдийн эрхийг зөрчсөн 35 контентыг устгах хүсэлтийг шууд харилцах /green channel/ сувгаар дамжуулан мэдээлж устгуулсан. 3.Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн хохирогч хүүхдийн зураг, дүрс бичлэгийг цахим орчноос устгах, нийтлэгчийг орж илрүүлэх IWF системд Монгол улсаас 3 хүсэлт илгээсэн байна. ШШЕГ-аас Монгол Улсад хүүхдийн байгууллага үүсгэн хөгжүүлсний 100 жилийн ой ХҮҮХЭД, ХАЙР, ИРЭЭДҮЙ уриалгын хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах, цахим орчинд зохистой хэрэглээний талаарх зурагт мэдээллийг байршуулж иргэд, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан. Мөн нийслэлийн болон аймгууд дахь шүүн шинжилгээний газар, хэлтсүүд цахим хуудаст гэр бүлийн тухай хуулийг байршуулан иргэд олон нийтэд түгээн ажиллаж байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам" сэдвээр подкаст, "Судалгаагаар хүүхдүүдийн 91% нь цахим дээрэлхэлтэд ямар нэгэн байдлаар өртөж байна", "Эцэг, эхчүүд хүүхдүүдээсээ цахим хэрэглээний мэдлэг хомс байна" сэдэвт рийлс, "Цахим орчинд хүүхдийг хамгаалах журам батлагдлаа" зурагт хуудас бэлтгэж, түгээлээ.	
--	--	--	--	--	--	--

					Зочин: Цагдаагийн дэд хурандаа ЦЕГ-ын урьдчилан сэргийлэх албаны Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс Хууль зүйн туслалцааны төвөөс “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвээр 1 рийл контентыг бэлтгэн, байгууллагын цахим хуудас болон байгууллагын фэйсбүүк пэйж хуудсаар олон нийтэд хүргэн 1847 хандалттай ажиллаж байна. Мөн цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, цахим хэрэглээний зохистой байдлын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор бусад байгууллагаас бэлтгэн гаргасан 1 видео контент, 1 подкаст, 1 портерыг байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк пэйжээр дамжуулан түгээж, нийт 6500 гаруй хандалт авсан. Эрх зүйн албан бус сургалтын хүрээнд “Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал” сэдвээр 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, 120 ахлах ангийн сурагч хамрагдсан. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг болон цахим аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 65 удаагийн сургалт зохион байгуулж, 4237 сурагч хамрагдлаа. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын байгууллагаас хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажилласан. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр 1073 постер, шторк, рийл, нэвтрүүлэг, видео контентыг бэлтгэн мэдээллийн хэрэгслээр түгээж давхардсан тоогоор 1,316,120 хүнд түгээж ажилласан.	
--	--	--	--	--	---	--

					Мөн цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 57 сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 114729 хүүхэд, 91820 эцэг эх асран хамгаалагчийг хамруулсан. Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс даван туулагч эмэгтэйчүүдэд цахим ур чадвар олгох цуврал сургалт (хаалттай дэмжих бүлэг) 10 удаагийн цуврал сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тус сургалт нь нийт 10 удаагийн цуврал үргэлжилсэн сургалтад хамрагдсан эмэгтэйчүүд компьютерын хэрэглээний программыг ашиглах, цахим орчинд мэдээллийн аюулгүй байдлаа хангах, цахим харилцаа холбоог үр дүнтэй ашиглах, контент бүтээх чадварт суралцсан байна. Мөн Даван туулагч эмэгтэйчүүдэд санхүүгийн боловсрол олгох цуврал сургалтыг Бүрэн Финанс ББСБ-тай хамтран зохион байгуулж байна. Тус сургалт нь нийт 4 удаагийн цувралаар үргэлжилсэн бөгөөд ийнхүү 4 удаагийн сургалт амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтад хамрагдсан эмэгтэйчүүд санхүүгээ удирдан төлөвлөх, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнийг харьцуулан судалж, оновчтой шийдвэр гаргах зэргээр эдийн засгийн бие даасан байдлаа бэхжүүлэх мэдлэг, ур чадварт суралцсан. Хүчирхийлэлд өртсөн хохирогч/ даван туулагчдад нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх ментор бэлтгэх хөтөлбөрийн III шатны сургалт зохион байгуулж, зочин багшаар Монголын Хуульчдын холбооны сургагч багш Г.Оюунболд, Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдлын ОУ-ын сургагч багш Б.Болороо нар ажилласан.	
--	--	--	--	--	--	--

					Сургалтад нийт 25 мэргэжилтэнүүд хамрагдсан байна. Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороонд ажиллан, жендэрт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сэдвээр сургалт зохион байгууллаа. Уг сургалтаар хүчирхийллийн төрөл хэлбэрүүд, түүний хор уршиг, хохирогчдод үзүүлэх хариу үйлчилгээ, мөн хүчирхийллийг мэдээлэх боломжуудын талаар оролцогчдод дэлгэрэнгүй мэдээлэл өгч, кейс дээр суурилсан харилцан ярилцлага, дасгал ажил, зөвлөмж зэргийг багтаасан практик сургалт явуулсан.Сургалтад тус хорооны иргэдээс бүрдсэн нийт 15 хүн хамрагдсан бөгөөд оролцогчид сургалтын төгсгөлд мэдээлэл өгөөжтэй, хэрэгцээтэй сургалт боллоо хэмээн үнэлж, цаашид ийм төрлийн сургалтыг тогтмол зохион байгуулах хэрэгцээтэй байгааг онцолсон юм.	
Гурав. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, шаардлагатай үйлчилгээ үзүүлэх, үнэлэх ажлын хүрээнд						
3.1	ДХИС-ийг түшиглэн байгуулсан “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг хэвшүүлэх	Үзүүлсэн хууль зүйн туслалцаа Ажилласан хүн хүч	ДХИС	ГХУСА33АА ХЗТТ, ХЗҮХ	ГХУСА33АА-наас ДХИС-ийг түшиглэсэн Хууль зүйн зөвлөгөө өгөх төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх” 5,000,000 төгрөгийн гэрээг байгуулан ажиллаж байна. ДХИС-иас тус их сургуулийн “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв”-ийн гадна харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайль үсгээр бичсэн хаягийг хадаж байршуулсан. 2025 онд тус төвд зөвлөгөө авахаар ирсэн 53 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч ажилласнаас 1 иргэн нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөвлөгөө авсан байна.	90

					Хууль зүйн туслалцааны төвөөс 2025 онд 12617 иргэн (давхардсан тоогоор)-д хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 738 нь гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийллийн зөвлөгөө мэдээлэл байсан. Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6-р зүйлд зааснаар 295 хохирогчид үнэ төлбөргүй туслалцаа үзүүлээ.	
3.2	Хорих ял шийтгүүлсэн, хорихоос суллагдсан, ХӨТЯШ хүүхэд болон тэдний гэр бүлд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны тоо Хамрагдсан гэр бүл, хүүхэд	ХГБХХЕГ	ШШГЕГ	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 2462 хүүхэд бүртгэлтэй байна. Хорооны үйлчилгээг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа болон сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан 2088, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 297, нийт 2385 хүүхэд хүргэсэн байна. Үүнд: Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдийг ангилавал: -Гэмт хэргийн сэжигтэн 204 -Гэмт хэргийн хохирогч 1003 -Гэмт хэргийн гэрч 222 -Зөрчил үйлдэж шийтгүүлсэн 324 -Зөрчлийн хэргийн хохирогч 302 -Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа 16 -Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан 17 хүүхэд байна. Хорооноос үзүүлсэн үйлчилгээг төрлөөр нь авч үзвэл: -Эрүүл мэндийн үйлчилгээг 645 -Боловсролын үйлчилгээг 382 -Нийгмийн халамжийн үйлчилгээг 220 -Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг 852 -Хууль эрх зүйн туслалцааг 1079	90

					-Хөгжлийг дэмжих үйлчилгээг 398 -Өмгөөллийн үйлчилгээг 152 -1322 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон ажилласан. Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тэдний хүмүүжил төлөвшлийг сайжруулахад анхаарч эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч нарт зориулсан сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулан шаардлагатай зөвлөмж, мэдээллийг өгч ажилласан.	
3.3	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх (ГБХТтХ-ийн 13.1.1)	Дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо Дэмжлэгийн хэлбэр	ГБХНХЯ	ХГБХХЕГ	Улсын хэмжээнд 26 түр хамгаалах байр, 12 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байгаагаас 23 ТХБ, 8 НЦҮТ нь Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтсийн харьяанд үйл ажиллагаагаа явуулж байна. 2025 оны 11 сарын байдлаар нийт 4699 иргэнд түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлснээс 1320 насанд хүрэгч, 3379 хүүхэд, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 154, урт хугацааны үйлчилгээнд 490 иргэн хамрагдсан. Нийт хүүхдийн 1964 буюу 58,1% эмэгтэй, 1411 буюу 41,7%, эрэгтэй, насанд хүрэгчдийн 93,4% эмэгтэй, 6,5% эрэгтэйчүүд байна. Дараагийн шатны үйлчилгээнд холбон зуучилсан байдлаар авч үзвэл: -Гэр бүлд эргэн нэгтгэсэн 1755 хүүхэд, 515 иргэн -Хамтарсан багт холбон зуучилсан 1972 хүүхэд, 441 иргэн -Бусад хамгаалах байранд шилжүүлсэн 89 хүүхэд, 47 иргэн -Асрамж халамжийн үйлчилгээнд 89 хүүхэд	100

					-Бусад үйлчилгээнд 312 хүүхэд, 172 иргэнийг тус тус холбон зуучилж, үйлчилгээ үзүүлж ажилласан байна. Харьяа байгууллага болох Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, Түр хамгаалах байр, үйл ажиллагаанд 2025 онд 358.3 сая төгрөг төсөв хуваарилсан. ГХУСАЗЗАА-аас Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын дэргэд ажилладаг жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зөвлөгөө мэдээлэл өгөх Чатбот үйлчилгээг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх зорилгоор Чатбот ХХК-тай үйлчилгээ үзүүлэх гэрээг хийн ажиллаж байна. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв нь 2025 оны 12 сарын 15-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 1147 хүн үйлчилүүлсэн байна. Үүнээс: Түр хамгаалах байранд -105, хүүхэд -82, насанд хүрсэн 23 хүнийг аюулгүй байдлыг нь хамгаалан байрлуулан цогц үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. Бэлгийн хүчирхийллийн бага насны хохирогч 12 хүүхдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлж, гэр бүлийн хүчирхийллийн 6 хохирогчийн өмгөөллийн үйлчилгээ, 2 хохирогчийн хууль ёсны төлөөлөгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан байна. 24 дуудлагыг цагдаагийн байгууллагад мэдээлсэн байна. Үүнээс: эрсдэлтэй нөхцөл байдал орсон 4 дуудлагад яаралтай тусламж үзүүлж хохирогчийн амь нас аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг авахуулж чадсан.	
--	--	--	--	--	---	--

					ХЭҮТ-ээс санал хүсэлт үлдээсэн 41 дуудлагад хариу үйлчилгээ үзүүлсэн байна. Чат бот үйлчилгээгээр дамжуулан холбогдсон эмэгтэй 2 хүүхдийг түр хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдсан. Чат бот үйлчилгээг нэвтрүүлснээр 24 цагийн турш хүчирхийллийн талаарх ойлголт мэдээллийг хүргэх, яаралтай тусламж дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой байна.	
3.4	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр иргэдэд сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгөх	Зөвлөгөө, туслалцаа авсан хүн	ХГБХХЕГ	ХЗТТ, ШШГЕГ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/04 дүгээр тушаалаар “Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үндэсний загварыг Хөвсгөл, Орхон аймагт бий болгох ажлыг эхлүүлж, цогц төв ажиллуулах арга зүйн чиглэлийг боловсруулж, ГБХНХ-ын сайдын 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/92 дугаар тушаалаар “Гэр бүлийн хөгжлийн үйлчилгээний төв ажиллуулах заавар, зөвлөмж”-ийг батлан, хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг 2025 оны 01/474 албан бичгээр аймаг, дүүргийн газар, хэлтэст хүргүүлэн, хэрэгжилтийг ханган ажилласан. Тухайлбал энэ онд Орхон, Баянхонгор, Сэлэнгэ аймгууд, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Батноров сум, Баянзүрх дүүрэгт нийт 6 Гэр бүлийн хөгжлийн цогц төвийг орон нутагт бий болгож, холбогдох төсвийг орон нутгийн зардлаар шийдвэрлүүлэн ажилласан. Иргэдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөг аймаг, дүүргийн газар, хэлтсийн дэргэдэх гэр бүлд зөвлөгөө өгөх 31 төвөөр дамжуулан үзүүлж ажилласан. 2025 оны 11 сарын байдлаар 55233 насанд хүрэгч, 39706 хүүхэд, 16335 гэр бүлд өгсөн. Гэр бүлийн хөгжлийг дэмжих зөвлөн туслах, хөгжлийг дэмжих үйлчилгээнд 376,433 гэр бүл буюу нийт гэр бүлийн 47,3 хувийг хамруулж, өмнөх оны мөн үеэс үйлчилгээнд	100

				хамрагдсан гэр бүлийн тоо 17,2 хувиар нэмэгдсэн. -Салбарын яамнаас гэр бүлийн гишүүдэд зөвлөгөө, мэдээллийг шуурхай хүргэх www.efamily.mn цахим платформыг E-Mongolia системд цэс үүсгэн хөгжүүлэх бэлтгэл ажлыг ханган, гэр бүлд зөвлөгөө өгөх 172 асуултыг бэлтгэн холбогдох байгууллагад хүргүүлсэн. Олон улсын гэр бүлийн өдрийн хүрээнд ГБНХНЯ болон харьяа агентлагууд хамтран “Ажилтай өрх- Аз жаргалтай гэр бүл” нэгдсэн арга хэмжээг Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Өдөрлөгөөр БЗД, СХД, ЧД-ийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтсээс “Уламжлалт Монгол гэр бүл”, “Орчин үеийн залуу гэр бүл”, “Байгууллага, аж ахуй нэгжийн хүүхэд хамгааллын бодлого, эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг сурталчлах асрууд ажиллуулан сэтгэл зүйн, хууль, эрх зүйн зөвлөгөө үйлчилгээг 111 иргэнд үзүүлсэн. Үндэсний уламжлалт тоглоом наадгай эвлүүлэх, хамтран тоглох, танилцуулах, хайртай хүмүүстэйгээ захидал бичих зэрэг үйл ажиллагаанд 1205 иргэнийг хамруулж нийт 1560 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. Хууль зүйн туслалцааны төвөөс 2025 оны байдлаар гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлаар нийт 283 иргэн Хууль зүйн туслалцааны төвийн 77001982 дугаарын утсаар болон биечлэн хандаж хууль зүйн зөвлөгөө авсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас гэр бүлд зөвлөгөө өгөх	
--	--	--	--	---	--

					чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: ШШГЕГ-ын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/706 дугаар албан бичгийн дагуу эмэгтэй хүмүүжигчдийг нийгэмшүүлэх чиглэлээр хүүхдийн баярын өдрийг угтан 2025 оны 05 дугаар сарын "Эх үрс-Итгэлт ирээдүй" өдөрлөгт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас хөгжлийн бэрхшээлтэй 3 эмэгтэй хүмүүжигчдэд ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан ба цаашид эмэгтэй хүмүүжигчдийн хүүхдүүдийг асран хамгаалах, үл хайхрахаас урьдчилан сэргийлэх асуудлаар холбогдох байгууллагад уламжлахаар ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/67 дугаар тушаалын дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Positive dadal сэтгэл зүйн байгууллагатай хамтран 8 удаагийн бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөөг нийт 89 (эрэгтэй 4, эмэгтэй-85) хүнд өгч ажилласан байна. Үүнд: -2025 оны 05 сарын 19-ний өдөр 10 хүнд "Гэр бүлийнхэн хэрхэн дэмждэг вэ?" сэдвээр; 2025 оны 05 сарын 28-ны өдөр 30 хүнд "Бэрхшээлээ хэрхэн даван туулж байсан бэ?", "Урам зориг эрч хүч хаанаас авч байдаг вэ?", "Гэр бүлийнхэн хэрхэн дэмждэг вэ?" сэдвээр; -2025 оны 10 сарын 15-ны өдөр 12 эцэг, эх, асран хамгаалагч сэтгэл зүйчийн зааварчилгаан дор нүдээ боож бэлтгэсэн	
--	--	--	--	--	---	--

					асуултын хүрээнд бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн; -2025 оны 11 сарын 13-ны өдөр 2 удаа тус бүр 17, 11 нийт 28 эцэг, эх, асран хамгаалагч сэтгэл зүйчийн зааварчилгаан дор нүдээ боож урьдчилан бэлтгэсэн асуултын хүрээнд харилцан яриа өрнүүлж, туршлага солилцсон. -2025 оны 11 сарын 27-ны өдөр 9 эцэг, эх, асран хамгаалагч сэтгэл зүйчийн зааварчилгаан дор нүдээ боож бэлтгэсэн асуултын хүрээнд харилцан ярилцаж сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн байна.	
Дундаж үнэлгээ						88.57

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДЭД ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.АМАРЖАРГАЛ

2025 оны 12 сарын 28 өдөр